

ТАНИЛЦУУЛГА


2024 оны эхний хагас жилийн байдлаар Боловсрол, шинжлэх ухааны яам болон түүний харьяа байгууллагуудад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

2024 оны 07 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам өссөн дүнгээр гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам (цаашид “БШУЯ” гэх) болон сайдад ажлаа шууд хариуцан тайлагнадаг харьяа байгууллагуудад 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3226 өргөдөл, гомдол, хүсэлт ирүүлсэн байна.



Иргэдээс Боловсрол, шинжлэх ухааны яам болон албан тушаалтанд хандан 2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 3226 өргөдөл, гомдол ирүүлснээс 35% нь цахимаар, 51,3% нь бичгээр, 13,7% нь биечлэн уулзсан байна.

Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилж үзвэл хүсэлт 2144 буюу 66,5%, санал 326 буюу 10,1%, гомдол 756 буюу 23,4% байна.



Хүснэгт. Ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга.

№	Тоо	Хувь	Өргөдөл гомдлын агуулга
1	553	17,1	Хууль эрх зүй, бодлого, үйл ажиллагааны чиглэлээр
2	995	30,8	Лавлагаа, бүртгэлийн чиглэлээр
3	763	23,6	Оюутны зээл, тусламж, тэтгэлгийн чиглэлээр
4	540	16,7	Төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийн чиглэлээр
5	375	11,8	Санхүүжилт, нийгмийн баталгааны чиглэлээр

Шийдвэрлэлт:

2024 оны эхний хагас жилд ирүүлсэн 3226 өргөдөл, санал, хүсэлтийн 3016 буюу 93,5 хувийг шийдвэрлэсэн дүнтэй байна. Шийдвэрлэгдээгүй 210 өргөдөл хугацаандаа судлагдаж байна.

Цаашид:

- Эрхэлсэн асуудлын чиглэлээр боловсруулах хууль тогтоомж, дүрэм, журам болон яамнаас баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаандаа иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд агуулагдсан санал, санаачилгыг тусгахад анхаарна.
- Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн үзүүлэлтийг харгалзан ажиллана.

БОЛОВСРОЛЫН ЯАМ